



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/338

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "д" заалт, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Мандалговь хотын төвд шинээр баригдах хоногт 3000 м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын хэрэгжилтэд удирдлага, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч

Дундговь Ус ОНӨҮГ-ын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого

төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Санхүү, төрийн сангийн хэлтсийн

дарга

Сайнцагаан сумын Засаг дарга

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын

дарга

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын

дарга

Аймгийн Газрын харилцаа, барилга

хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Байгаль орчин, аялал

жуулчлалын газрын дарга

БЗӨБЦТС ТӨХК-ийн Мандалговь дахь

салбарын ерөнхий инженер

Хоёр. Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд орон нутгаас шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч, төслийн явц болон ажлын хэсгийн ажлын талаарх мэдээллийг тухай бүр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

Гурав. Аймгийн Засаг даргын 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн А/03 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190967